Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 1. *Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах | | | | | | | |
| 1.1 | Нийгмийн даатгалын багц хууль (шинэчилсэн найруулга) болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах | Тухай бүр | 100% | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, өдөр тутам хэрэгжүүлэн ажиллах. | Тайлант хугацаан ХНХЯам болон НДЕГазраас Нийгмийн даатгалын багц хууль хэрэгжүүлэхтэй холбоотой ирүүлсэн 11 заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийг хүлээн авсан байна.<br>Ирсэн журам, заавар чиглэлтэй тухай бүр хариуцсан албан хаагчдад танилцан ажлын байран дээр мөрдлөг болгон ажиллаж байна.<br>2024 оны 12 дугаар сарын 26 ны өдрийн Журам, заавар, өргөдлийн маягтын загвар батлах тухай А/246 дугаар тушаалаар Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэлд хяналт тавих, тэтгэврийн хувийн хэрэг бүрдүүлэх, бүртгэх журам" Тэтгэвэр бодох заавар" Өндөр насны тэтгэвэр тогтоолгох өргөдлийн маягтын загвар" Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох маягтын загвар"-ын дагуу даатгуулагч нараас хүсэлтийг авч байна.<br>Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр НДЕГ-БХСГазраас 2025 оны 06 дугаар сарын 02ны өдрийн 04/1360 албан тоот зөвлөмжийн дагуу дагуу НДСОТТухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтын нөхцөл шаардлагыг тавихгүйгээр цэргийн алба хаасны болон өндөр насны тэтгэврээс өөрт таатай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нөхцөлөөр тэтгэврийг нэг удаа өөрчлөн тогтоох хүсэл одоогоор ирээгүй байна .Харин ЦАХТТТХуулийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу ажилласан жилийг дундаж цалингаас 1.5% өөрчлөн тогтоож байна. | |
| **Хоёр. *Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| ***Зорилт 2:*** Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах | | | | | | | |
| 2.1 | **Арга хэмжээ 2.1.** Тэтгэврийн даатгалын сангаас өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдалтын, тэжээгчээ алдсаны тэтгэвэр Цэргийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгосон тэтгэвэр мөн даатгуулагчдыг зөвлөгөө мэдээллээр хангах | Тухай бүр | 100% | 100%-иас доошгүй | Тус газрын батлагдсан төсвийн хуваарийн дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон Цэргийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэврийн цаг хугацаанд нь олгох. 417.475.672.500 төг | Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тухай Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн хуулийн хүрээнд нийт 36885 тэтгэвэр авагч нарт нийт 208.241.849.954 төгрөгний тэтгэврийг олгосон байна.<br>Тайлант хугацаанд шинээр:<br>• Өндөр нас: 729<br>• Тахир дутуу 336<br>• Тэжээгчээ алдсаны 40<br>• Цэргийн тэтгэвэр 35<br>Шинээр нийт 1140 тэтгэврийг тогтоон цаг хугацаанд нь олгосон байна.<br>Давхардсан тоогоор 10,000 гаруй даатгуулагч тэтгэвэр авагч нарт Нийгмийн даатгалын шинэчлэгдсэн багц хуулийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>Тайлант хугацаанд эрхийн харилцаа дуусгавар болсон<br>• Нас барсан 263<br>• Зогсоогдсон 201<br>• Шилжиж ирсэн 84<br>• Шилжин явсан 58 тэтгэвэр авагчийн хөдөлгөөнийг цаг хугацаанд нь хийсэн.<br><br>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон цэргийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу нэмэлт өөрчлөлт хийлгэсэн 1180 тэтгэвэр авагчийн авагчийн анхан шатны материалыг хүлээн авч тэтгэврийг хуулийн дагуу цаг хугацаанд нь олгосон байна.<br>Мөн Эрүүл мэндийн магадлах зөвлөлөөр сунгалт хийлгсэн 688 ХЧА тэтгэвэр болон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тэжээгчээ алдсаны тэтгэврийн сунгалтыг цаг хугацаанд нь хийж тэтгэврийг бүрэн олгосон.<br>Мөн 2024 онд хөдөлгөөн хийж тэтгэврийн харилцаа дууссан дараах тэтгэврүүдийг архивт хүлээлгэн өгч ажилласан. Үүнд:<br>• Өндөр насны 590<br>• Тахир дутуу 481<br>• Тэжээгчээ алдсаны байна 26 байна. | |
| 2.2 | **Арга хэмжээ 2.2.** Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөр чадвар түр алдсаны, жирэмсэн амаржсаны болон оршуулгийн тэтгэмж олгох, даатгуулагчдыг зөвлөгөө мэдээллээр хангах | Тухай бүр | 100% | 100%-иас доошгүй | Тус газрын батлагдсан төсвийн хуваарийн дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох.<br>22.622.781.200 төг | Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 7000 гаруй аж ахуй нэг байгууллага ажил олгогч болон даатгуулагч нарт тэтгэмжийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй үзүүлж зөвлөгөө мэдээллийг биеэр болон цахимиар өгч ажиллаж байна.<br>• Хөдөлмөрийн чадвар түр алдсан 6161 даатгуулагчдад 2.751.563.334 төгрөг<br>• Жирэмсэн амаржсан 1766 даатгуулагчдад 7.927.006.517 төгрөг<br>• Оршуулга тэтгэмжийг 356 даатгуулагчдад 712.000.000 төгрөг олгож ажилласан байна.<br>Нийт дүнгээр 11.390.569.851 төгрөгний тэтгэмжийг олгож ажилласан байна. | |
| 2.3 | **Арга хэмжээ 2.3.** Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох, даатгуулагчдыг зөвлөгөө мэдээллээр хангах | Тухай бүр | 100% | 100%-иас доошгүй | Тус газрын батлагдсан төсвийн хуваарийн дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох ҮОМШӨТТТ тухай хуулийн дагуу тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох.<br>2.947.080.000 төг мян.төг | Тайлант хугацаанд<br>ҮОМШӨ-ий улмаас Хөдөлмөрийн чадвар түр алдсан 279 даатгуулагчдад 141.778.488 төгрөгийг олгож ҮОМШӨ-ий сувиллын зардлыг 2 даатгуулагчид 898.001 төгрөг олгон ажиллсан байна.<br>ҮОМШӨ-ний<br>**Хөдөлмөрийн чадвар** алдалтын тэтгэвэрт 149 даатгуулагчийн 963.289.864.төгрөг,<br>**Тэжээгчээ алдсан** тэтгэвэрт 27 даатгуулагчийн 175.905.237 төгрөг буюу нийтдээ 1.281.871.590 төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олгож ажилласан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4 | **Арга хэмжээ 2.4.** Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох, даатгуулагчдыг зөвлөгөө мэдээллээр хангах | Тухай бүр | 100% | 100%-иас доошгүй | Тус газрын батлагдсан төсвийн хуваарийн дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох. 19.039.831.000 төг | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн хүрээнд давхардсан тоогоор 4515 даатгуулагчдад 10.018.162.422 төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж бодож, олгосон байна.<br>Сард 2 удаа ажилгүйдлийн тэтгэмж авч буй 4515 даатгуулагчдыг ажилд орсон эсэхийг нэгдсэн баазаас шалган ажиллаж байна.<br>2024 оны эрхийн харилцаа дуусгавар болсон 3539 ажилгүйдлийн хувийн хэргийг архивлан хүлээлгэн өгсөн. | |
| **Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | | | | | | | |
| 3.1 | **Арга хэмжээ 3.1.** Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон Газар, хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | Тухай бүр | 100% | 100%-иас доошгүй | Шалгалтын үр дүнг тухай бүрд тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган, актын барагдуулалтыг 50 дээш хувиар барагдуулан мэдээ, тайланг хүргүүлж ажилласан байна. | Өмнөх онуудын НДЕГ, ННДГ болон дотоод хяналт шалгалтын Улсын байцаагчийн актын барагдуулалт давхардсан тоогоор 55 тэтгвэр авагчаас нийт 22.291.426 төг суутгал хийж актын барагдуулалт хийсэн.<br>Газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу тэтгэвэр авагч иргэдийн тэтгэврийн тогтоолт, олголтын үндэслэл, тэтгэвэр авагчийн хувийн хэрэг болон мэдээллийн нэгдсэн сан болон холбогдох бусад материалыг үндэслэн шалгаж шинээр нийт 19 тэтгэвэр авагчдад нийт 92.733.302 төгрөгийн акт тавигдаснаас 50.839.073 төг барагдуулж 54,8 хувийг барагдуулсан байна.<br>Газрын даргын баталсан<br>Дотоодын хяналт шалгалтаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, НДСангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэмж авч буй даатгуулагч нарын тогтоолт олголтыг хувийн хэрэг болон мэдээллийн нэгдсэн сантай тулган шалгаж 62 даатгуулагч нарт 48.854.580.60 төгрөгийн акт тавьж, барагдуулалтыг 100 хувь хийсэн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025.01.07-ны өдрийн 13-07/06 тоот удирдамжийн 2022-2024 оны ажилгүйдлийн тэтгэмж авсан даатгуулагч нарын тогтоолт олголтыг хувийн хэрэг болон мэдээллийн нэгдсэн сантай тулган шалгаж 7 даатгуулагч дээр 40.369.691 төгрөгийн акт тавигдсанаас 601,484 төг барагдсан байна. | |
| **Зорилт 4.** ***Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 4.1. | **Арга хэмжээ №4.1.** Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх; | Хэрэгжилтийн хувиар | 100% | 100%-иас доошгүй . | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байх | Тайлант хугацаанд ХНХЯам болон НДЕГазраас Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой дагаж мөрдөх 11 заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийг хүлээн авч хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 4.2 | **Арга хэмжээ №4.2.** Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах | Тухай бүр | 100% | 100%-иас доошгүй | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн 100 хувь хугацаанд нь шийдвэрлэн ажиллана. | Тайлант хугацаанд нийт 63 өргөдөл гомдлыг хүлээн авснаас 61 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн, судлагдаж байгаа 1 өргөдөл байна.<br>Хугацаа хоцорсон өргөдөл байхгүй.<br>Шийдвэрлэлтийн дундаж хугацааны индекс 0.9 байна.<br>Ирсэн хэлбэр:<br>✓ Бичгээр - 36<br>✓ 11-11 төвөөс - 3<br>✓ 1800-1200 дугаарын оператороос-0<br>✓ Дээд газраас –11<br>✓ Албаны майлээр -13 | |
| 4.3 | **Арга хэмжээ №4.3.** Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон | Тухай бүр | 100% | 100%-иас доошгүй | Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний | Төрийн үйлчилгээг иргэд даатгуулагч ажил олгогч нарт хүртээмжтэй түргэн шуурхай үзүүлхийн тулд Нийгмийн даатгалын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах | | | | стандартын хэрэгжилтийг хангаж ажиллана | газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангаж тав тухтай орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Нэг цонхоор нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй үзүүлж өдөрт дунджаар 200-300 гаруй иргэд даатгуулагч ажил олгогч нарт төрийн үйлчилгээг үзүүлж байна. Цахим үйлчилгээг www.portal.ndaatgal.mn хаягаар болон нийгмийн даатгалын апп программыг сурталчлан таниулж түүгээр дамжуулан үйлчилгээг түргэн шуурхай авч болохыг сурталчлан таниулан ажиллаж байна. | |
| | | | | | | Мөн иргэд, даатгуулагч нарт төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор дүүргийн ЗДТГазарт нэг цонхны үйлчилгээгээр тайлант хугацаанд 1162 гаруй даатгуулагч нарт үйлчилгээг үзүүлсэн байна. | |
| ***Зорилт 4.2:** "Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.2.1 | **Арга хэмжээ №4.2.1** Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах | Тухай бүр | 100% | 100%-иас доошгүй | Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна. | | |
| 4.2.2 | **Арга хэмжээ №4.2.2** "Цахим архив"-ыг үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах | Тухай бүр | - | 100%-иас доошгүй | Иргэд даатгуулагчдад чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчлэх зорилгоор цахимаар архивын үйлчилгээ, ажилласан жил, шимтгэл төлсөн лавлагаа, тэтгэврийн хувийн хэрэг зэрэг олон төрлийн үйлчилгээг шуурхай авах боломжтой болно. | Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчдад чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчлэх зорилгоор цахимаар тэтгэмжийн /ЖА, ХЧТүр алдалт, ажилгүйдэл, ҮОМШӨ ХЧТүр алдалт/ материалыг хүлээн авч мөн тайлант хугацаанд шинээр тэтгэвэр тогтоолгож буй 1140 даатгаагуулагчийн анхан шатны материалыг цахимжуулан ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.3 | **Арга хэмжээ №4.2.3** Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; | Тухай бүр | 100% | 100%-иас доошгүй | Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна. | Тайлант хугацаанд Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай хүргэж калл про үйлчилгээг 72001289-с шууд байцаагчийн гар утсанд дуудлага шижүүлэхээр зохион байгуулж ажилласан.<br>Тайлант хугацаанд тэтгэмжийн утсанд нийт 14,540 дуудлага ирснээс 9003 буюу 62 хувь хариулсан, даатгуулагч дохисон буюу өөрөө салгасан 2373 буюу<br>16.3 хувь, алдсан болон давхардсан дуудлага 1811 буюу 12.4 хувь байна.<br>Тэтгэврийн үйлчилгээнд нийт 3541 дуудлага ирснээс 2682 буюу 75.7 хувь, хариулсан 668 буюу 18.8 хувь, дохисон буюу өөрөө салгасан 158 буюу 0.4 хувь нь давхар орж ирсэн дуудлага байна. | |
| Зорилт 4.3. Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.3.1 | **Арга хэмжээ №4.3.1** Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулж, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлж ажилласан байх | Хэрэгжилтийн хувиар | 100% | 100%-иас доошгүй | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авсан байна. | 2025 оны 06 дугаар сард Ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулахаар төлөвлөж байна. | |
| 4.3.2 | **Арга хэмжээ №4.3.2** Орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах, эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах чиглэлээр холбогдох | Хэрэгжилтийн хувиар | 100% | 100%-иас доошгүй | Хийсэн судалгаа, дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх бууруулах чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан хүргүүлсэнээр | Баянгол дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон иргэдийн тоог 2025 оны эхний хагас жилийн байдлаар программд 5562 иргэн, дүүргийн нийт хүн амын тоотой (252979) харьцуулбал хүн амын 2,1 хувийг эзэлж байна. Тус дүүрэгт дотор, мэдрэл, чих хамар хоолой, нүд, гэмтэл, мэс заслын /хавдар/ эмгэгүүд эхний 6 байрыг эзэлж байгаа бөгөөд эдгээр нь нийт хөдөлмөрийн чадвар алдалтын 21,3 хувийг эзэлдэг. 2024 онд 5562 иргэн хөдөлмөрийн чадвар алдалттай байсан бөгөөд тэргүүлэгч 5 | |

<table>
<tr><td></td><td>байгууллагуудтай хамтран ажилласан байх</td><td></td><td></td><td></td><td></td><td>өвчлөлийг дүүргийн эрүүл мэндийн үзүүлэлттэй харьцуулбал:
<table>
<tr><th>Өвчлөл</th><th>ЭМТ-н нийт үзлэг</th><th>ХЧА шинээр тогтоосон</th><th>Эзлэх хувь</th></tr>
<tr><td>Дотор</td><td>18073</td><td>98</td><td>0,5%</td></tr>
<tr><td>Мэдрэл</td><td>12166</td><td>40</td><td>0.3%</td></tr>
<tr><td>Гэмтэл</td><td>11658</td><td>52</td><td>0.4%</td></tr>
<tr><td>Чих хамар хоолой</td><td>1905</td><td>6</td><td>0.3%</td></tr>
<tr><td>Нүд</td><td>4529</td><td>21</td><td>0.4%</td></tr>
</table>
Үр дүн: Баянгол дүүргийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалт нь улсын дунджаас доогуур нийт хүн амынхаа 2,1 хувийг эзэлж байна.</td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичиг /амбулаторийн карт, рентгент зураг, CD8 DVD зэрэг/-ийн эмх цэгц, хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнд хүрсэн байна.</td><td>Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн хадгалалт, эмх цэгцийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хороодын эмч нартай хамтарч ажиллаж байна. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дахин магадлалаар Эмнэлгийн хувийн хэргийн эмх цэгц, хадгалалт хамгаалалт болон хөтлөлт хангалттай сайн гэсэн үнэлгээ авсан.<br>Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлүүлж буй иргэдийн амбулаторийн карт дахь үечилсэн дүгнэлтэд өвчний түүх, оношилгоо, шинжилгээний өөрчлөлт, өвчний үе шат, явц, хийгдсэн эмчилгээ, түүний үр дүн болон биеийн байдлын талаар дэлгэрэнгүй бичиж хэвшсэн;<br>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн төлөвлөгөөг жил бүр батлуулж гишүүн бүрд тодорхой арга хэмжээг хариуцуулан, үр дүнг тооцож ажилласан байна.</td><td></td></tr>
<tr><td>4.3.3</td><td>Арга хэмжээ №4.3.3 Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, тогтоомжийг танилцуулах,</td><td>Хэрэг жилти йн</td><td>100%</td><td>100%-иас доошгүй</td><td>Эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудас бичилт олголттой холбоотой хууль</td><td>Монгол улсын засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор баталсан Дүрэм, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн</td><td></td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүд болон иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах | хувиар | | | тогтоомж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүдэд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна | хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/177, А/433 тоот хамтарсан тушаал үндэслэн 2024 оны 12 дугаар сарын 09-ний байдлаар хөдөлмөрийн чадвар түр алдалт болон жирэмсэн, амаржсаны тэтгэмжийг цаг алдалгүй хянаж, иргэн датгуулагчид хүргэж байна. Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/441, А/192 тоот хамтарсан тушаалыг үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар ЭММЗ нь иргэн /даатгуулагч/-ийг байлцуулан 24 удаа хуралдан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, сунгаж, цуцалж шийдвэрлэснээс 303 иргэнд шинээр тогтоож, 907 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгаж, 141 иргэнийг цуцалж, шилжиж явсан 22 иргэн, шилжиж ирсэн 31 иргэн, нас барсан 9 иргэн байна.<br>ЭММЗ-ийн мэдээллийн сангийн мэдээлэлд дотоод хяналт хийсэн. Тэтгэврийн байцаагч нартай хамтарч хөдөлмөрийн чадвар алдсан иргэд биеийн байдал сайжирсан, эмчийн хяналтын хугацаа дууссан, сунгуулахгүй, хянуулахгүй хаяж явсан, нас баралт бүртгэгдээгүй иргэдийг бүртгэлээс хассан. | |
| | | | | | | Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт харьяалагддаг Эрүүл мэндийн байгууллагуудад Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор баталсан Дүрэм, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/177, А/433 тоот хамтарсан тушаал, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/441, А/192 тоот хамтарсан тушаалын хавсралтаар Хөдөлмөрийн чадвар алдалтаар эмнэлгийн хуудас | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичиж, олгох журмаар сургалт зохион байгуулсан. Сургалтад Улсын 3-р төв эмнэлэг, Эх нялхсын эрүүл мэндийн үндэсний төвийн дүн бүртгэгч эмч, Төмөр замын эмнэлгийн эмч нар, Эрүүл мэндийн 7-р төвийн нарийн мэргэжлийн эмч нар, 34 өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар оролцсон.<br><br>Монгол улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 448 дугаар тогтоолоор баталсан Дүрэм, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/177, А/433 тоот хамтарсан тушаалын хэрэгжилт, тус дүүргийн 5562 иргэн /даатгуулагч/-н хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн даатгуулагчийн эрхийг хамгаалах, хангахын тулд мэдээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг бий болгох, Монгол улсын Нийгмийн даатгалын тухай багц хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийг үндэслэн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцох нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Өдөрлөгт Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газар, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран ажилласан бөгөөд уг өдөрлөгийг МҮОНР телевизээр 1 удаагийн мэдээ бэлтгэн 3 удаагийн давтамжтай, UBS телевизээр мөн 1 удаагийн мэдээ бэлтгэн 3 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж, олон нийтийг мэдээ мэдээллээр хангаж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.4 | **Арга хэмжээ №4.3.4** Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөлмжийн хэрэгжилтийг зохион байгуулах | Хэрэг жилтийн хувиар | 100% | 100%-иас доошгүй | Хэрэгжүүлсэн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн тоогоор | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс 9 чиглэл, зөвлөмж, албан даалгавар ирж хариутай бичиг болон судалгааг хугацаанд нь хүргүүлж ажилласан. | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэл | | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Үндэсний бичгийн танхимын сургалтанд хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох; | Албан хэрэгхөрвүүлэх унших чадвартай болсон байна. | НДЕГазраас цахимаар зохион байгуулсан Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдсан, анхан шатны түвшинтэй байна. | Албан хэрэг хөрвүүлэх хөтлөх | БГДүүргийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран зохион байгуулсан Үндэсний бичиг-ийн сургалтан хамрагдаж үндэсний бичгийн мэдлэг чадвараа дээшүүлсэн. | |
| 2 | Төрийн албан хаагчийн мэдлэг ур чадвар сайжруулах сургалт, хөтөлбөрт хамрагдах | Төрийн албан хаагчийн хувьд төрийн албаны болон бусад хууль тогтоомжийн талаарх мэдлэг чадвартай болсон байна | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан цахим сургалтуудад хамрагдсан. | Мэдлэг чадвараа дээшлүүлэх | Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ" танхимын суралтанд хамрагдсан мөн НДЕГ зохион байгуулсан НД- н багц хууль болон бусад цахим сургалтуудад хамрагдан хууль эрх зүйн мэдлэгээ сайжируулсан. | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга ................................ / Б.СУГАР / ......... ......... .........

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )